



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/100

Мандалговь

Сумын Залуучуудын хөгжлийн зөвлөл
байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 а, л, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 13 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”-ийн 5.2.8 дахь заалт, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоол, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Залуучуудын үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, хөгжил оролцоо, санал санаачилгыг дэмжих болон тэдгээрийн эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах зорилгоор сумын Залуучуудын хөгжлийн зөвлөлийг байгуулсугай.

2.Залуучуудын хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг харъяа төсөвт байгууллагын залуучуудын зөвлөлийн дарга, багийн залуучуудын төлөөллөөс сонгож хавсралтаар баталсугай.

3.Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”-ийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Сумын Залуучуудын хөгжлийн зөвлөлийн дарга (И.Эрдэнэцог)-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж хагас, бүтэн жилээр тайлагнахыг Сумын Залуучуудын хөгжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга (О.Уранзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

